



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР**

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг
тогтвортой хэвийн явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх
тухай

Дэлхий нийтэд тархаад буй Корона вирусээс урьдчилсан сэргийлж Улсын онцгой комиссоос улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан зам, тээврийн салбарын үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

1. Салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх талаар бүх талын боломжтой арга хэмжээ авч ажиллахаас гадна улсын төсөв болон бусад эх үүсвэрийн санхүүжилтийг зүй зохистой зарцуулах, тэвчиж болох зардлыг хэмнэх, хэмнэгдэж буй томилолтын зардлыг оновчтой хуваарилан зарцуулах зэргээр зардлыг хэмнэх бүх талын арга хэмжээ авч ажиллахыг харьяа байгууллага, салбарын төрийн өмчийн компаниудын дарга, захирал нарт;

2. Зорчигч тээвэрт цахим төлбөр тооцооны системийг нэвтрүүлэх, цагийн хуваарийн уян хатан зохицуулалтыг хийх, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, тээвэрлэлтийг харилцан уялдаатай зохион байгуулах, хот хоорондын зорчигч тээврийн дамжин суух нөхцөлийг бүрдүүлэх зэргээр үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах бүх талын арга замыг судлан хэрэгжүүлж ажиллахыг “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компани, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг болон тээвэрлэгч аж ахуйн нэгж, компаниудын дарга, захирал нарт;

3. Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар өртөөнд холимог тээврийн зохион байгуулалтыг сайжруулах, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Бүс нутгийн логистикийн төвийн үйл ажиллагааг автотээврийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах арга замыг судлан хэрэгжүүлэхийг Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгт;

4. Салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах үүднээс Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/-д;

4.1 Зам, тээврийн салбарт эрсдэлийн сан бий болгох хууль эрх зүйн орчныг судалж шийдвэрлүүлэх;


4.2 Авто замын барилга, засвар, төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай дотооддоо үйлдвэрлэх боломжгүй, зайлшгүй импортоор оруулж ирэх машин механизм, техник, тоног төхөөрөмжийг НӨАТ болон гаалийн албан татвараас чөлөөлүүлэх, гадаадаас түрээсэлсэн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг гаалийн түр горимоор оруулж ирэхэд гаалийн албан татварын барьцаа байршуулахаас чөлөөлүүлэх талаар арга хэмжээ авах;

4.3 Ковид-19 халдварт цар тахлын оргил үе өнгөрсний дараах эдийн засгийн сэргэлттэй уялдуулан үүсэх нөхцөл байдалд зам тээврийн салбар бэлэн байдлыг хангах төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллах;

4.4 Зам, тээврийн салбарын үндэсний компаниудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор түншлэл хэлбэрээр томоохон бүтээн байгуулалтад оролцуулах чиглэлээр салбарын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

5. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН